



## ЭРХЭМ ХАРИЛЦАГЧ ТАНАА “БУЛЛ КАПИТАЛ ББСБ”ХХК-ийн 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА.

Бид 2024 оны эхний хагас жилд Бизнес төлөвлөгөөний дагуу тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн ханган ажиллалаа. Үүнд:

№	Үндсэн ажиллагааны хүрээнд:
1	Компанийн 2023 оны Санхүүгийн тайлан, гүйцэтгэлийг хэлэлцэж, нийт ажилтнуудад үр дүнгийн урамшууллыг хуваарилж олгосон.
2	Компанийн ТУЗ-өөр эцэслэн батлагдсан 2024 оны Төсвийн төлөвлөгөөний дагуу бүх нэгжүүдэд төлөвлөгөөний хуваарилалт хийгдсэн.
3	Компанийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Өлзийт аккаунт аудит” ХХК-аар хөндлөнгийн аудит хийлгэж, баталгаажуулан Банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны вэб сайтаар дамжуулан олон нийтэд түгээсэн.
4	 ҮЦАЭХ-ны зөвшөөрлийн дагуу Биржийн бус зах дээр 2024 оны 03-р сарын 06-ны өдөр жилийн 19.0 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай, 5.8 тэрбум төгрөгийн дүн бүхий “Булл бонд 4”-ийг хаалттай хүрээнд “Мандал капитал маркетс”ҮЦК - тай хамтран амжилттай гаргасан.
5	Биржийн бус зах зээлээс 2023 оны 2 сард татан төвлөрүүлсэн 2.2 тэрбум төгрөгийн дүнтэй “Булл бонд 2”-ийг хүүний хамт бүрэн төлж хаасан, мөн Санхүүгийн байгууллагууд болон “Булл бонд 3”, “Булл бонд 4”-ийн хөрөнгө оруулагчид мөн Итгэлцэл байршуулсан харилцагчдын өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь бүрэн биелүүлэн ажилласан.
6	Байгууллагын хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд 11 ажилтан шинээр нэмж, 4 ажилтан албан тушаал дэвшиж нийт үндсэн ажилтны тоо 34 болсон.
7	“Архивын заавар”, “Орон сууцны жишиг үнэлгээ”, “Албан хэрэг хөтлөл”, “Сургалт хөгжил”-ийн журамууд шинээр батлуулсан. Нийт ажилтнууд дунд заавар, журмын танигдалтын ажлыг зохион байгуулсан.
8	Нийт ажилтнууддаа зориулж нийт 19 цагийн 7 удаагийн сургалт, салбар болон газар, хэлтсийн захирлуудаа 104 цагийн 12 удаагийн сургалтад хамруулсан.
9	Компани нь дотоод үйл ажиллагааг сайжруулах, ажилтны мэдлэг ур чадварыг чадавхижуулах зорилгоор долоо хоног бүр дотоод сургалтыг зохион байгуулж, гадаад сургалт, хэлэлцүүлгүүдэд (СЗХ-оос зохион байгуулсан “Комплаенсийн эрсдэлийн үнэлгээг гаргах тухай”, ТОС холбооноос зохион байгуулсан ББСБ-уудын Гүйцэтгэх захирлуудад зориулсан “Тогтвортой санхүүжилт” сургалт, хэлэлцүүлэг, МИК ОССК-ийн БОНЗ-ын тайлагналын системтэй танилцах, туршлага судлах уулзалт, Нийслэлийн онцгой байдлын газраас зохион байгуулсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хүрээнд хөгжүүлэх, эрсдэлийг бодитоор



	бууруулах, даван туулах чадварыг нэмэгдүүлэх тухай болон хүрээлэнгээс зохион байгуулагддаг эрсдэлийн үнэлгээ, сургалт) тус тус хамрагдуулсан.
10	Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 4-р сард Улаанбаатар хотын шинэ сууршилын бүсэд шинэ ашиглалтад орсон Horse motors Автомашины худалдааны төвд “Яармаг салбар”-ыг шинээр байгуулсан.
11	СЗХ-оос ББСБ-уудад хийгдсэн газар дээрх шалгалтад хамрагдаж “Үйл ажиллагаа хэвийн, сайн” гэсэн үнэлгээг авсан.
12	Зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Санхүүгийн газраас мөнгөн урсгал төлөвлөлтийг долоо хоног бүр, Эрсдэл хариуцсан нэгжээс зээлийн эрсдэлийн хяналтыг өдөр бүр хийж байна.
<b>Хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр:</b>	
13	Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын үйл ажиллагааны хүрээнд: <ul style="list-style-type: none"><li>✓ 2024.02.08-ны өдөр Тос Холбооны мэргэжлийн зөвлөлийн уулзалтад оролцсон. Тос холбооны төлөвлөгөө, ажиллах зарчим, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлэлцэж, тодорхойлоход оролцсон.</li><li>✓ Тос холбооны гишүүн банкуудын ТОС-ын хэрэгжилтийн хүрээнд хийсэн болон хийж буй ажлуудтай танилцах арга хэмжээнд оролцсон.</li></ul>
14	Байгууллага хоорондын хамтын ажиллагаа нэмэгдүүлэх, хамтран суралцах, мэдээлэл туршлага солилцох зорилгоор “Худалдаа аж үйлдвэрийн танхим”-ийн гишүүнээр элсэх хүсэлтээ өгөөд байна.
<b>Нийгмийн хариуцлагын хүрээнд:</b>	
	Жил бүр уламжлал болгон зохион байгуулладаг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.
15	Байгууллагын нийт ажилтанд “Амьдралын хэв маяг, эрүүл зөв хооллолт” сургалтыг Аюурвэд төвийн багш А.Болортуяагаас авсан.
16	Компанийн нийт ажилтнууд болон тэдний гэр бүлийнхний дунд нөхөрсөг спорт өдөрлөг зохион байгуулсан. 
17	Бидний хамгийн чухал үнэ цэнэтэй зүйл эрүүл мэнд. Ажилтан нэг бүрийнхээ эрүүл мэндэд илүү анхаарч ирсэн. Энэ хүрээнд “Дөрөвдүгээр эмнэлэг” болон “Nura Mongolia” эрт илрүүлэгийн эмнэлгүүдэд эрүүл мэндийн цогц шинжилгээ, оношлогоо үзлэгт нийт ажилтнуудаа хамруулсан.
18	Эх үрсийн баярыг тохиолдуулан нийт ажилтнуудынхаа энхрий бяцхан хүүхдүүдтэй “Adventure zone” тоглоомын төвд нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлж, мөн шинээр ажилд орсон залуу ажилтнууддаа болон хүүхдүүддээ компанийн зүгээс хүүхдийн баярын бэлэг гардуулсан.

19



Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг байгаль орчинд ээлтэй ажлын хүрээнд хамт олноороо 2024 оны 6-р сарын 19-ны өдөр Богд Уулын “Дугуй цагаан” ойр орчмын хогийг цэвэрлэсэн.

### Эрсдэлийн бодлого:

Эдийн засаг, зах зээлийн нөхцөл байдал, төрийн зохицуулагч байгууллагуудын бодлого шийдвэрийг анхааралтай ажиглаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийг түргэн шуурхай авч ажиллаж байна. Энэ хүрээнд өмнөх оноос хэрэгжүүлж эхэлсэн дараах шийдвэрүүдийг мөрдсөөр байна.

1. Төвлөрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг харилцагчид 200.0 сая төгрөгөөс дээш хэмжээний зээл олгохгүй байх,
2. Эдийн засгийн сектороор хязгаарласан зээлийн багцын хязгаарууд болон барьцаа хөрөнгийн үнэлгээний бодлогыг чангаруулах,
3. Уул уурхай, барилгын салбар болон эдгээр салбаруудтай хамаарал бүхий орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгохгүй,
4. Өр орлогын харьцааны шаардлагыг чангаруулах.

### Санхүүгийн үзүүлэлт:

Бид Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн ханган ажиллаж байгаа ба 2022, 2023 оны жилийн эцсийн болон 2024 оны I, II улирлын санхүүгийн тайлангийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай байна. Үүнд:

Үзүүлэлтүүд /сая.төг/	2022	2023	2024.IQ	2024.II	Өөрчлөлт	Өөрчлөлт
	Аудитлагдсан	Аудитлагдсан	СЗХ-нд илгээсэн.	СЗХ-нд илгээсэн.	2024.2Q/ 2024.1Q	2024.2Q/ 2023
<b>Санхүү байдлын тайлан</b>						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,209.36	3,286.55	3,406.25	4,842.72	<b>42%</b>	<b>47%</b>
Нийт зээл	22,223.77	47,597.28	57,708.90	70,014.00	<b>21%</b>	<b>47%</b>
Зээлийн эрсдэлийн сан	-124.27	-722.17	-533.73	-714.05	<b>34%</b>	<b>-1%</b>
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	626.34	1,515.54	1,460.43	2,022.13	<b>38%</b>	<b>33%</b>
Бусад авлага	217.12	0.00	0.00	75.57	<b>100%</b>	<b>100%</b>
Бусад хөрөнгө	40.65	296.74	1,670.75	1,267.66	<b>-24%</b>	<b>327%</b>
Үндсэн хөрөнгө	173.63	217.02	206.38	210.72	<b>2%</b>	<b>-3%</b>
<b>Нийт хөрөнгийн дун</b>	<b>25,366.60</b>	<b>52,190.96</b>	<b>63,918.97</b>	<b>77,718.75</b>	<b>22%</b>	<b>49%</b>

<b>Итгэлцэл, бусад өр төлбөр</b>	<b>16,314.42</b>	<b>33,686.94</b>	<b>43,036.69</b>	<b>53,869.74</b>	<b>25%</b>	<b>60%</b>
Итгэлцэл	7,155.15	14,068.71	14,242.98	17,184.00	97%	86%
Зээлийн эх үүсвэр	5,895.25	11,595.43	17,148.83	25,418.70	97%	114%
Бонд	2,200.00	5,600.00	9,200.00	9,200.00	155%	109%
Бусад өр төлбөр	1,064.03	2,422.79	2,444.88	2,067.03	128%	223%
Дүрмийн сан	7,400.00	12,199.83	12,199.83	12,199.83	0%	0%
Хуримтлагдсан ашиг	1,652.17	6,304.19	8,682.45	11,649.18	34%	85%
<b>Нийт өр төлбөр, эзний өмчийн дүн</b>	<b><u>25,366.60</u></b>	<b><u>52,190.96</u></b>	<b><u>63,918.97</u></b>	<b><u>77,718.75</u></b>	<b>22%</b>	<b>49%</b>
<b>Орлого үр дүнгийн тайлан</b>						
Хүүгийн орлого	4,109.23	13,399.17	4,923.08	11,178.23	14%	67%
Хүүгийн зардал	963.16	5,122.17	2,187.99	4,682.06	7%	83%
<b>Цэвэр хүүгийн орлого</b>	<b>3,146.07</b>	<b>8,277.01</b>	<b>2,735.09</b>	<b>6,496.17</b>	<b>19%</b>	<b>57%</b>
Хүүгийн бус орлого	229.49	992.93	517.70	734.16	-29%	48%
Хүүгийн бус зардал	1,390.35	1,381.86	651.93	1,239.56	-5%	79%
Эрсдэлийн сангийн зардал	124.27	597.89	0.00	0.00	-100%	-100%
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>	<b>1,860.94</b>	<b>7,290.19</b>	<b>2,600.87</b>	<b>5,990.77</b>	<b>15%</b>	<b>64%</b>
Ү/А-ны бус орлого		0.00	0.00	0.00	0%	0%
Ү/А-ны бус зардал	47.49	95.83	20.79	47.56	14%	-1%
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>1,813.46</b>	<b>7,194.36</b>	<b>2,580.07</b>	<b>5,943.21</b>	<b>15%</b>	<b>65%</b>
Орлогын татварын зардал	184.09	890.34	201.81	598.22	48%	34%
<b>Цэвэр ашиг</b>	<b>1,629.37</b>	<b>6,304.02</b>	<b>2,378.26</b>	<b>5,344.99</b>	<b>12%</b>	<b>70%</b>

2024 оны II улиралд 2023 оны жилийн эцсийн үзүүлэлттэй харьцуулахад нийт хөрөнгө 25.5 тэрбум төгрөгөөр буюу 49%-иар, нийт зээлийн багц 22.4 тэрбум төгрөгөөр буюу 47%-иар тус тус өссөн. Чанаргүй зээлийн нийт зээлийн багцад эзлэх хувь 1.59% байна.

2024 оны эхний хагас жилд хаалттай хүрээнд “Булл бонд 4”-ийг амжилттай борлуулж 5.8 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж, мөн Банк, санхүүгийн байгууллагаас болон итгэл хүлээлгэгч нараас эх үүсвэр татсанаар Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн дүн 51.8 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 66%-иар өссөн байна.

Дээрх үзүүлэлтүүдийн үр дүнд 2024 оны II улирлын байдлаар татварын дараах цэвэр ашиг 5,344.99 сая төгрөгт хүрч, Санхүүгийн зохицуулах хорооноос тавьдаг зохистой харьцааны бүх шалгууруудыг ханган ажиллалаа.